

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,  
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2014 оны 01 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар А/КЭГ.93

Улаанбаатар хот

Гэрээний загварыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам"-ын 4.4 дэх заалт, 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ын 1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөр, амьжиргааны зардал олгох гэрээ"-ний загварыг 1 дүгээр, "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ"-ний загварыг 2 дугаар, "Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын хөтөлбөрт суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ"-ний загварыг 3 дугаар, "Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын хөтөлбөрт суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний хавсралт үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ"-ний загварыг 4 дүгээр, "Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ"-ний загварыг 5 дугаар, "Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний хавсралт үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ"-ний загварыг 6 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам", 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам", 2013 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам"-ын дагуу зээл, буцалтгүй тусламжаар суралцагчидтай 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн шинэчлэн баталсан загвараар гэрээ байгуулж, санхүүжилтийн тооцоо хийх ажлыг зохион байгуулахыг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан "Гэрээний загварыг шинэчлэн батлах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 70/369 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Ц.Баярхүү/-т, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР



Ч.УЛААН



**ГАДААД ОРНЫ ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД  
МАГИСТР, ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧДАД ЗЭЭЛ ОЛГОХ, ЭРГЭН  
ТӨЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

201.... оны ....дугаар  
сарын ....-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

**НЭГ. Ерөнхий зүйл**

1.1.Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын суралцах хугацаандаа сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зориулалтаар авсан санхүүжилтийг сургалтын гэрээний нөхцөл зөрчсөн тохиолдолд эргэж төлөгдөх баталгааг хангах, гэрээнд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлоход гэрээний зорилго оршино.

1.2.Сургалтын төрийн сан, суралцагчийн хооронд байгуулсан гэрээ нь Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох, журам", 2014 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам"-аар (цаашид "журам" гэнэ) зохицуулагдана.

1.3.Энэхүү гэрээг нэг талаас Сургалтын төрийн сангийн нэрийн өмнөөс ..... албан тушаалын ажилтай ..... /ургийн овог/ ..... /эцэг /эх/-ийн нэр/ ..... /өөрийн нэр/, нөгөө талаас суралцагч ..... аймаг (хот) ..... сум (дүүрэг) ..... -баг (хороо) ..... гудамж ..... хорооллын ..... байрны ..... тоотод оршин суугч ..... регистрийн дугаартай ..... /ургийн овог/ ..... /эцэг/эх/-ийн нэр/ ..... /өөрийн нэр/ нь (цаашид "суралцагч" гэнэ) ..... улсын ..... сургуульд ..... мэргэжил /хөтөлбөр/-ээр ..... жил суралцан төгсөж ирэхээр харилцан тохиролцож дараах нөхцөлөөр байгуулав.



1.4.Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж Сургалтын төрийн сан, Улсын бүртгэлийн холбогдох байгууллага, суралцагч тус бүр хадгална. Гэрээтэй холбогдсон маргаантай асуудлыг талууд харилцан тохиролцож чадахгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

1.5."Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээний хавсралт үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ" нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

1.6.Сургалтын төрийн сангаас суралцагчдад олгох зээлийн хэмжээ, санхүүжилтийн хуваарь:

д/д	Хичээлийн жил	Зээлийн хэмжээ		
		Бүгд	Сургалтын төлбөр	Амьжиргааны зардал
1.				
2. г.м				

### **ХОЁР. Сургалтын төрийн сангийн эрх, үүрэг**

2.1.Энэхүү гэрээнд заасан сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг сургуулийн нэхэмжлэлийг үндэслэн сургалтын төлбөрийг суралцах сургуулийн дансанд, хүсвэл амьжиргааны зардлыг суралцагчийн харилцах дансанд бэлэн бусаар шилжүүлнэ.

2.2.Суралцагчийн суралцаж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагын тодорхойлолт, сурлагын дүнг үндэслэн дараа жилийн төлбөрийг шилжүүлнэ.

2.3.Сургалтын гэрээнд сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын тухай тэмдэглэл хийж баталгаажуулна.

### **ГУРАВ. Суралцагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

3.1.Миний бие ..... оны ..... дүгээр сарын ..... –ны өдрөөс эхлэн ..... улсын ..... сургуульд ..... мэргэжил /хөтөлбөр/-ээр амжилттай суралцаж гэрээний хугацаанд төгсөж эх орондоо ирнэ.

3.2.Өөрийн талаарх дээд боловсролын сургалтын байгууллагын албан ёсны тодорхойлолтыг, сургалтын дүнгийн хамт гэрээгээ сунгуулахдаа Сургалтын төрийн санд өгнө.

3.3.Суралцах хугацаандаа тухайн улс орны хууль тогтоомж, ёс заншил, хувийн сахилга хариуцлагыг чанд сахиж, сургалтын хөтөлбөрийн шаардлагыг тогтоосон

хугацаанд ханган биелүүлж, мэргэшлийн тодорхойлолтод заасан мэдлэг, чадварыг бүрэн эзэмшинэ.

3.4. Суралцах хугацаандаа тухайн оронд суугаа, эсхүл тухайн орныг хамаарагч Монгол Улсын Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газрын иргэний бүртгэл мэдээлэлд хамрагдаж, байнгын холбоотой байна.

3.5. Хүүхэд төрүүлэх, өвчний улмаас холбогдох хууль тогтоомжийн дагуу чөлөө авсан тохиолдолд энэ тухайгаа Сургалтын төрийн санд албан ёсоор мэдэгдэнэ.

3.6. Сургуулиа төгсөж эх орондоо ирснээс хойш ажлын 21 хоногийн дотор Сургалтын төрийн санд өөрийн биеэр ирж мэдэгдэнэ.

3.7. Төгсөж ирээд “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай” хуулийн 8.8-д заасан журмын дагуу зээлийг эргэн төлж барагдуулна.

3.8. Төгсөгч сургалтын болон амьжиргааны төлбөрийн зээлийг заасан хугацаанаас нь өмнө төлж барагдуулж болно.

3.9. Гэрээгээ зөрчсөн тохиолдолд зээлийг Сургалтын төрийн санд буцааж төлнө. Хэрэв авсан зээлийг өөрөө төлж чадахгүйд хүрвэл суралцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь зээлийн төлбөрийг бүрэн хариуцна.

3.10. Эх орондоо байхгүй байсны улмаас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг өөрөө биелүүлж чадахгүйд хүрвэл миний итгэмжлэгдсэн төлөөлөгч болох ..... аймаг (хот) ..... сум (дүүрэг) ..... баг (хороо) ..... гудамж ..... хорооллын ..... байрны ..... тоотод оршин суугч ..... регистрийн дугаартай ..... /ургийн овог/ ..... /эцэг /эх/-ийн нэр/ ..... /өөрийн нэр/ нь бүрэн хариуцана.

#### ДӨРӨВ. Гэрээний сунгалт

Д/Д	Курс	Хичээлийн жил	Гэрээг сунгасан (он, сар, өдөр)	Гэрээ хүчинтэй байх хугацаа	Зөвшөөрсөн суралцагч (итгэмжлэгдсэн төлөөлөгч)-ийн гарын үсэг	Сургалтын төрийн санг төлөөлж гэрээ сунгасан албан тушаалтны гарын үсэг (тамга, тэмдэг)
1.						
2.гм						

**Гэрээ байгуулсан:**

Сургалтын төрийн санг төлөөлж:  
Албан тушаал.....  
Ургийн овог.....  
Эцэг /эх/-ийн нэр.....  
Өөрийн нэр .....  
Гарын үсэг.....


(тамга, тэмдэг)

Суралцагч:  
Ургийн овог.....  
Эцэг /эх/-ийн нэр.....  
Өөрийн нэр .....  
Гарын үсэг.....

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч:**

Ургийн овог.....  
Эцэг /эх/-ийн нэр.....  
Өөрийн нэр .....  
Гарын үсэг.....





**ГАДААД ОРНЫ ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД МАГИСТР,  
ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧДАД ЗЭЭЛ ОЛГОХ, ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ  
ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ГЭРЭЭ**

201.... оны ....дугаар  
сарын ....-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Энэхүү ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ГЭРЭЭ-г Монгол Улсын “Иргэний хууль”-ийн нийтлэг журам, “Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай” хуулийг тус тус үндэслэн

-Нэг талаас Сургалтын төрийн сан, түүнийг төлөөлж .....албан тушаалын ажилтай..... /ургийн овог/ ..... /эцэг /эх/-ийн нэр/ ..... /өөрийн нэр/ (цаашид “барьцаалагч” гэнэ),  
-Нөгөө талаас ..... аймаг (хот) .....сум (дүүрэг) ..... баг(хороо) ..... гудамж..... хорооллын ..... байрны ..... тоотод оршин суух ..... /ургийн овог/ ..... /эцэг /эх/-ийн нэр/ ..... /өөрийн нэр/, (регистрийн дугаар ..... ) (цаашид “зээлдэгч буюу” “барьцаалуулагч” гэх, хамтад нь “талууд” гэнэ) нар нь дор дурдсан нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ. Ерөнхий зүйл**

1.1.Энэхүү гэрээгээр талуудын хооронд ..... оны .....-р сарын .....-ны өдөр байгуулсан Сургалтын төрийн сангийн “Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын хөтөлбөрт суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээ”-ний (цаашид “Үндсэн гэрээ” гэнэ) үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон барьцаалуулагчийн хууль ёсны эрхийнхээ дагуу үл хөдлөх хөрөнгөө барьцаалахтай холбогдох харилцааг зохицуулна.

1.2.Барьцаалуулагч нь зээлийн гэрээний үүргийг хангах зорилгоор энэхүү гэрээнд заасан барьцаа хөрөнгийг барьцаалуулахыг хүссэн бөгөөд зээлийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд барьцааны зүйлийг шүүхээр шийдвэрлүүлэх замаар зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахыг хүлээн зөвшөөрч уг гэрээг байгуулсан болно.

1.3.Талууд өөрөөр тохиролцоогүй бол барьцааны эрх барьцаалбараар гэрчлэгдэхгүй.

### ХОЁР. Барьцааны зүйл, барьцааны эрх

2.1.Барьцааны зүйл: Барьцаалуулагчид нь зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор дараах үл хөдлөх хөрөнгийг барьцаалуулж байна. Үүнд:

№	Барьцаа хөрөнгийн мэдээлэл	Тайлбар
1	Барьцаа хөрөнгийн нэр, зориулалт	
2	Байршил, хаяг, талбайн хэмжээ	
3	Барьцаа хөрөнгийн эзэмшигчийн нэр/с/	
4	Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар	
5	Бүртгэсэн байгууллагын нэр, огноо	
6	Барьцаа хөрөнгийн талаар харилцан тохиролцсон үнэлгээ	
7	Барьцаа хөрөнгийн барьцаалуулсан эсэх тухай лавлагаа, дугаар	
8	Барьцаа хөрөнгийн талаархи гуравдагч этгээдийн эрх	
9	Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрхийг олж авсан гэрээний үндсэн нөхцөл, хугацаа	

2.2.Барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ “Үндсэн гэрээ”-гээр тодорхойлогдох бөгөөд ..... төгрөгийн үндсэн зээл байна. /Валютын ханшийг тухайн өдрийн Монголбанкны ханшаар хөрвүүлэн тооцно./

2.3.Барьцаагаар хангагдах үүргийг “Журам батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох, журам”-д зааснаар гүйцэтгэнэ.

2.4.Барьцааны зүйл барьцаалагчийн өмчлөлд эс бол түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмчлөлд байна. Барьцааны өмчлөлийн зүйлийг өөрчлөх тохиолдолд заавал барьцаалагчийн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтийн дагуу тухайн барьцаа өмчлөгчийн зөвшөөрлийн үндсэн дээр талууд харилцан тохиролцон шийдвэрлэнэ.

2.5.Барьцаалуулагч барьцааны зүйлийг бүхэлд нь хамгаалах үүрэг хүлээнэ.



2.6. Барьцааны зүйл өөрчлөгдөх нь зээлийн гэрээг өөрчлөх, цуцлах хүчингүй болгох, дуусгавар болгох үндэслэл болохгүй.

2.7. Барьцааны зүйл нь барьцаалуулагчийн эс бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хууль ёсны өмчлөл мөн бөгөөд энэхүү барьцааны зүйлд нэхэмжлэл үүсээгүй, хуулийн шаардлага хангасан байна. Зээлдэгч зээлийн гэрээний үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

### **ГУРАВ. Барьцаалуулагчийн эрх**

3.1. Барьцаагаар хангагдах үүрэг бүрэн биелэгдсэн тохиолдолд барьцааны зүйлийг барьцаанаас суллахыг шаардана

3.2. Барьцаагаар хангагдах шаардлагыг бүрэн биелүүлэх замаар барьцаалагчийн шүүхээр шийдвэрлүүлэхээс өмнө зогсоох эрхтэй.

3.3. Барьцааны зүйл нь талуудын хооронд байгуулсан гэрээ, хэлцэл болон хууль, тогтоомжийг зөрчин бусад гуравдагч этгээдэд барьцаалах, үрэх, устгах, гэмтээх, чанараа алдаснаас үнэлгээ буурах, үүний улмаас энэ гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахгүй болох тохиолдолд барьцаалуулагч бусад эд хөрөнгөөрөө хохирлыг бүрэн хариуцна.

3.4. Бусдын хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр хууль бусаар барьцаалуулсан, барьцаа хөрөнгийн бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлснээс үүсэх хариуцлагыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хүлээж, барьцаалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцана.

3.5. Барьцааны зүйлийн өмчлөх болон бусад эрхийн талаар шүүхээс хэрэг үүсгэн барьцаалуулагчийг хариуцагчаар татсан бол барьцаалуулагч энэ тухай барьцаалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

### **ДӨРӨВ. Барьцаалагчийн эрх, үүрэг**

4.1. Зээлдэгч зээлийн гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүй бол энэ гэрээнд заасан журмаар захиран зарцуулна.

4.2. Барьцааны зүйлийн даатгалын тохиолдол гарсан бол даатгалын төлбөрөөс тэргүүн ээлжинд зээлийн төлбөрийг барагдуулах эрхтэй.

4.3. Зээлийн гэрээний үүрэг бүрэн хангагдсан тохиолдолд барьцаа хөрөнгийг чөлөөлөх үүрэгтэй.

### **ТАВ. Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах**

5.1. Зээлдэгч нь зээлийн гэрээний үүргээ зөрчсөн, зээлийн төлбөрийг хэсэгчлэн төлөх, зээлийг бүхэлд нь төлөх хугацаандаа төлөөгүй тохиолдолд дараах өдрөөс

барьцааны зүйлээр зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх Барьцаалагчид, үүрэг Барьцаалуулагчид үүснэ.

5.2.Барьцааны зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулж зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрхтэй.

5.3.Барьцаагаар хангагдах шаардлага үүссэн тохиолдолд Барьцаалагч барьцааны зүйлээр зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай хуульд заасны дагуу Барьцаалуулагчид 7(долоо) хоногийн хугацаатай шаардах мэдэгдлийг бичгээр мэдэгдэнэ.

### **ЗУРГАА. Бусад зүйл**

6.1.Энэхүү зээлийн барьцааны гэрээ хүчин төгөлдөр болсны үндсэн дээр талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, нотариатаар гэрчлүүлж, эрхийн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр зээлийн барьцааны гэрээ хууль зүйн хүчин төгөлдөр болно.

6.2.Энэхүү “Үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ”-г талууд харилцан тохиролцож үйлдсэн бөгөөд эрх шилжүүлэн авагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хүлээн авагч болон зөвшөөрөгдөн томилогдсон этгээдүүдийн хувьд зайлшгүй дагаж мөрдөх зүйл болно.

6.3.Энэхүү “Үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулах нөхцөлд түүнийг бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурснаар гэрээний нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

6.4.Энэхүү “Үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ” нь монгол хэл дээр 3 эх хувь үйлдэгдэх бөгөөд эх хувиуд адил хүчинтэй байна.

6.5.Энэхүү “Үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ” нь “Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ”-ний салшгүй хэсэг болно.

### **Гэрээ байгуулсан:**

Барьцаалагчийг төлөөлж:

Сургалтын төрийн сангийн

Албан тушаал.....

Ургийн овог.....

Эцэг /эх/-ийн нэр.....

Өөрийн нэр .....

Гарын үсэг.....

(тамга, тэмдэг)

Барьцаалуулагчийг төлөөлж:

Суралцагч:

Ургийн овог.....

Эцэг /эх/-ийн нэр.....

Өөрийн нэр .....

Гарын үсэг.....

Итгэмжлэгдсэн төлөөлөгч:  
Ургийн овог.....  
Эцэг /эх/-ийн нэр.....  
Өөрийн нэр .....  
Гарын үсэг.....